



249
169

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 104

Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ойн тухай хуулийн 17.1.1, дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд ногоон байгууламжийг хоёр дахин нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах ая тухтай орчинг бүрдүүлэх зорилго бүхий "Ногоон Алтай" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Ногоон Алтай" дэд хөтөлбөрийг жил бүр аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган ажиллах, шаардлагатай төсөв хөрөнгийг улс, орон нутгийн болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулан нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/ -д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
30-ны өдрийн 104 дүгээр тогтоолын
I хавсралт

“НОГООН АЛТАЙ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийд уул уурхай, химийн болон хүнд үйлдвэр хөгжиж, хүнээс шалтгаалсан байгаль орчинд сөрөг нөлөөтэй, хор хөнөөл ихтэй үйл ажиллагаа ихэссэнээс агаар мандлын нүүрс хүчлийн хий ихсэж дулаарал бий болж, цөлжих аюул нүүрлээд байна. Энэ үйл явц Монгол оронд, тэр дундаа байгаль, экологийн эмзэг бүтэцтэй Говь-Алтай аймагт илүү ихээр нөлөөлж бэлчээрийн 70 хувь нь доройтолд орж байна.

Ойн сангийн хувьд 1664625 мянган га талбай заган ой, 10456 мянган га талбай шинэсэн ой тархан ургаж ойн сан бүхий талбай 1675081 мянган га талбай буюу нийт газар нутгийн 0.9 хувийг эзэлж байна.

Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ аймаг, сумын хэмжээнд маш бага талбайг хамарч байна. Тухайлбал зарим сумд огт ногоон байгууламж бий болгох боломжгүй, ногоон байгууламжгүй сум байна.

Мөн газар нутгийн онцлогоос гадна тухайн төв суурин газрын усан хангамжийн асуудал болох худаг, уст цэгийн тоо, төлөвлөлтийн буруу нөхцлөөс шалтгаалан төв суурин газар ногоон байгууламж байгуулах газаргүй болсон айл өрхүүд хашаа хатгасан, газар олгохдоо ногоон байгууламжийн асуудлыг орхигдуулсан барилга байгууламж барихдаа 10 хувьд ногоон байгууламж байгуулах газрыг нь тусгаж өгдөггүй зэрэг шалтгаанаар ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэхгүй байна.

Жил бүр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу хавар, намарт олон нийтийг хамруулан мод тарих хөдөлгөөн өрнүүлж байгаа боловч арчилгаа, усалгаа, хамгаалалтын байдлаас шалтгаалан төдийлөн үр дүнд хүрэхгүй байна.

Есөнбулаг сумын тухайд хариуцаж байгаа байгууллага нь усалгааны машин хүрэлцээгүйгээс усалгаа муудаж модны амьдралтын хувь буурч байна.

Ойн сангийн хувьд 1664625 мянган га талбай заган ой, 10456 мянган га талбай шинэсэн ой тархан ургаж ойн сан бүхий талбай 1675081 мянган га талбай буюу нийт газар нутгийн 0.9 хувийг эзэлж байна

1.2. Өнөөгийн нөхцөл байдал

1.2.1. Газарзүйн байршил: Монгол Алтайн нурууны үргэлжлэл, гол томоохон нурууд болох Мянган угалзтын нуруу, Бүс хайрхан, Алаг хайрханы уулс, Их хүрэн, Баян-Өндөр уул, Хар азаргын нуруу, Бурхан буудай уул, Гичгэний нуруу, Аж богдын нурууд цэнхэртэн харагддагаас аймгийн хамгийн өндөр нь мөнх цаст

бөгөөд үүнээс гадна Аж богд /3802 м/, Бурхан буудай /3765м/, Алаг хайрхан /3738м/, Хасагт хайрхан /3578м/, Бүс хайрхан /3393 м/, Буга хайрхан зэрэг байгалийн үзэсгэлэнт өндөр уулс оршино.

Томоохон говь, хотгор хонхоруудын гадаргын үнэмлэхүй өндөр 743-1100 орчим метр, өөрөөр хэлбэл далайн түвшингээс дээш дунджаар 1000 гаруй метр өргөгдсөн Хүйс, Шарга, Захуй, Зарман, Шаралдайн, Номин, Нарансэвстэйн, Төхөм, Улаан шалын хоолой, Хонин ус, Бигэр, Халиун зэрэг Монголын нэрд гарсан 33 говийн 13 нь оршдог. Эдгээрээс хамгийн нам өндөрлөгтэй нь Цэнхэр номингийн говь /583 м/ юм.

Тус аймагт өндөр уулын, хуурай хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Бас чийглэгдүү хүйтэн тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал хагас цөл нутаг хийгээд өндөр уулын оройн хэсэгт бүрэлджээ. Говь-Алтай аймаг нь Монгол Улсдаа газар нутгийнхаа хэмжээгээр 2 дугаарт буюу Өмнөговь аймгийн дараа ордог бөгөөд Монгол орны баруун урд хэсэгт орших 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, хойд талаараа Завхан, зүүн талаараа Баянхонгор, баруун талаараа Ховд аймаг, өмнөд хэсгээрээ БНХАУ-тай тус тус хиллэдэг.

Аймгийн төв нь Улаанбаатар хотоос 1001 км алслагдсан, бусад аймгуудын төвөөс хамгийн өндөрт өргөгдсөн бөгөөд далайн түвшнээс дээш 2181м, ойролцоогоор Богд хан уулын оройтой тэнцэхүйц хэмжээний өндөрт оршдог. Бусад бүсээс ялгаатай нь говь, хангай хосолсон өргөн уудам нутагтай далайн түвшнээс дээш 721-4079 метр өндөрт, газар хөдлөлийн идэвхитэй бүсэд оршдог. Дэлхийн цагийн 6 дугаар бүсэд байрладаг бөгөөд уул, тал, хөндий, уужим говь, тавиун хотгор, хонхор хосолсон газрын гадаргуутай. Аймгийн нутаг дэвсгэр нь газрын дүрс мужлалын хувьд алтайн уулархаг их муж, говийн их мужид хамаарах бөгөөд байгалийн бүс бүслүүрийн хувьд гол төлөв говь, цөлийн бүсэд оршино. Мөн бага хэмжээгээр хээр тал болон өндөр уулсын босоо буюу тагийн бүслүүр тархсан байдаг. Засаг захиргааны 18 сум, 2 тосгон 87 багтай.

1.2.2. Уур амьсгал: Эх газрын эрс тэс уур амьсгалтай учир цаг агаарын гамшигт үзэгдэл тохиолдох нь элбэг, эдийн засаг нь байгаль, цаг уурын нөхцөлөөс хараат байдаг. Тус аймагт өндөр уулын, тал хээрийн, цөлөрхөг говь хээрийн уур амьсгал зонхилно. Бас чийглэгдүү хүйтэн, тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал хагас цөл нутаг хийгээд өндөр уулын хормойн хэсэгт бүрэлджээ. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд дундажлсан агаарын олон жилийн дундаж температур 1.08°C байна.

Харин аймгийн хур тунадасны хувьд жилд дунджаар Алтайн нурууны салбар уулс, Сутай хайрхан, Хантайширын нуруу, Гичгэний нуруугаар 120-250 мм, Хүйс, Шарга, Бигэрийн говь хоолой болон Алтайн өвөр говиор 40-120 мм орчим тунадас унадаг бөгөөд жилийн нийт хур тундасны 85 орчим хувь нь дулааны улиралд буюу 4-9-р сар түүнээс зөвхөн 6-8-р сард 66.2 хувь нь ордог байна. Жилийн дундаж салхины хурд 2-5м/с хүрдэг бөгөөд шороон шуурга ууландаа жилд дунджаар 35-37, говьд 56-59 өдөр шуурдаг.

Иймээс хур хунадас маш бага унадаг учир ургамал ургах вегатацийн хугацаа харилцан адилгүй байна. Шарга, Алтай, Гуулин, Халиун, Бигэр,

Баянтоорой зэрэг газруудад ургамал ургах хугацаа урт байна. 3 сараас эхлээд 11 сар хүртэл ургаж байхад бусад сумдад 5 сараас нахиа задарч 9 сарын 15 гэхэд ургамал унтах талруугаа орж ургамлын үргэлт зогссон байна. 3 сарын хугацаанд хичнээн биеэ дааж ургасан ч 5-15 см ургаж байна бусад газар 20-30 см өндөр ургаж байна. Иймд орон нутагт дасан зохицсон тарьц суулгацаар ойжуулалт хийх шаардлагатай байна.

1.2.3. Хүн ам: Тус аймагт 16.3 мянган өрхөд 56.7 мянган хүн амьдарч байгаагаас 5053 өрх аймгийн төвд, 306 өрх тосгонд, 3900 өрх сумын төвд, 6995 өрх хөдөө амьдарч байна. Аймгийн нийт хүн амын 30.2 хувь буюу 17.1 мянга нь аймгийн төвд, 25.2 хувь буюу 14.3 мянга нь сумын төвд, 43 хувь буюу 24.4 хувь нь хөдөө, 1.6 хувь буюу 0.9 мянга нь тосгонд амьдарч байна. Хүн амын жилийн дундаж өсөлт 1,0 хувьтай, дундаж наслалт 67.87 байна.

Төв суурин газар амьдарч байгаа иргэдийг нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээтэй харьцуулж тооцоход 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 20,4 байна. Монгол улсын хэмжээнд 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг дэлхийн дундажтай харьцуулж дагаж мөрддөг. Дэлхийн дундаж 20,4 га талбай байдаг. Үүнд хүргэхийн тулд улс болон аймаг, сум, багийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр үе шаттайгаар арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

1.2.4. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбар: Мал аж ахуйн салбарт 2016 оны жилийн эцсийн мал тооллогоор 3497.5 мянган толгой мал тоологдсоноос адуу 106.8 мянга, үхэр 71.1 мянга, тэмээ 38.5 мянга, хонь 1107.1 мянга, ямаа 2173.9 мянган толгой мал тус тус тоологдсон байна. Энэ нь өмнөх оноос адуу 20.8 хувиар, үхэр 20.9 хувиар, тэмээ 1.1 хувиар, хонь 21.8 хувиар, ямаа 18.7 хувиар өссөн дүнтэй байна.

Тус аймагт 17 услалтын системийг түшиглэн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэдэг бөгөөд нийтдээ 4230 га талбайг ашиглах боломжтойгоос, 2016 онд үр тариа 525.3 тн, төмс 633.1 тн, хунсний бусад ногоо 468.8 тн, малын тэжээлийн ургамал 1479 тн-г тус тус хураасан байна. Мөн 5169.3 тн байгалийн хадлан, 283.2 тн гар тэжээл, 2879.5 тн хужир шүү тус тус бэлтгэсэн. Энэ нь аймгийн хэмжээнд хангалттай тоо биш байна. Тариалангийн талбайг нэмэгдүүлэх атаршсан газрыг нөхөн сэргээх тал дээр авч хэрэгжүүлсэн ажил байхгүй тариалангийн талбайд салхинаас хамгаалсан ойн зурвас байгуулах ажил хийдээгүй байна.

1.2.5. Ногоон байгууламжийн өнөөгийн байдал: Сүүлийн жилүүдэд орон нутгаас байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас жилд 3-5 га талбайд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах, хадлан тариалангийн талбайг салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг хийж байна.

2000-2017 оны хугацаанд улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 279 га талбайд салхинаас хамгаалах ойн зурвас, ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгээд байна.

253.
173

Төв суурин газрын ногоон байгууламж аймгийн хэмжээнд 86.87 га талбай байна. Энэ нь улс болон бусад аймгийн хэмжээнд харьцангуй бага тоо юм. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аймаг, сум, багийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Сумдын ногоон байгууламжийн хэмжээ

д/д	Сумын нэр	Хэмжээ /га/
1	Алтай	11.7
2	Баян-Уул	2.59
3	Бугат	6.4
4	Дэлгэр	8.6
5	Цогт	3.2
6	Цээл	0,1
7	Тайшир	0.7
8	Эрдэнэ	0.93
9	Төгрөг	2.4
10	Тонхил	4.19
11	Жаргалан	5.92
12	Халиун	8.38
13	Хөхморьт	5
14	Шарга	1.56
15	Дарив	0.67
16	Чандман	6.2
17	Бигэр	6.2
18	Есөнбулаг	10.23
Нийт дүн		86,87

1.2.6 Тулгамдаж буй асуудал

Ногоон байгууламж хариуцсан тасагтай болох: Аймгийн хэмжээнд ногоон байгууламжийн усалгаа арчилгааны муу байгаагаас тухайн жилд хийгдсэн ойжуулалт, ойн зурвас байгуулах, мод тарих өдрийн хүрээнд хийгдэж байгаа ажлууд үр дүн муутай болж байна. Есөнбулаг сумын хэмжээнд Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аймгийн төвийн ногоон байгууламжийг бүрэн хариуцаж услаж, арчилж, тайралт таналт хийж мэргэжлийн байгууллагын хэмжээнд ажиллаж чадахгүй байна.

Ногоон байгууламж хариуцсан тасаг байгуулах, усалгааны машины тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн хүмүүс ажиллуулах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

2.1. Хөтөлбөрийн зорилго:

Монгол улсын Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Ногоон хөгжлийн бодлогыг улс орны хөгжлийн тулгуур бодлогын нэг болгох" заалт, аймгийн Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Ногоон Алтай дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн хэмжээнд ногоон байгууламжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх" зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, төв суурин газрын тохижилтыг сайжруулах, байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого,

арга хэмжээг аймаг, сум, баг, орон нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөсний үндсэн дээр ногоон зурвас, ногоон төгөл байгуулах, дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилт:

2.2.1. Төв суурин газрын тохижилтыг сайжруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор урт болон богино хугацааны аян, хөдөлгөөнийг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах.

2.2.2. Мэргэжлийн боловсон хүчээр хангаж, техник тоног төхөөрөмж шинэчилхэд дэмжлэг үзүүлэх

2.2.3. Сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, иргэдийг түшиглэн сумдад мод үржүүлгийн газар байгуулах, мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж ойг нөхөн сэргээх замаар экологийн сөрөг нөлөөллийг багасгах, өргөтгөх ажилд дэмжлэг үзүүлэх.

2.2.4. Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн санаачилга, оролцоог нэмэгдүүлж, ногоон төгөл байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдийг жимс, жимсгэний болон бусад мод бут сөөг тариалахад дэмжлэг үзүүлэх.

2.2.5. Төв суурин газрын усан хангамж, ногоон байгууламжийн усалгааны асуудлыг шийдвэрлэх

2.2.6. Заг болон шинэсэн ойг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ авч, нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалах

Гурав. Хөтөлбөрийн хугацаа

Хөтөлбөрийг 2017-2020 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

4.1. “Төв суурин газрын тохижилтыг сайжруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор урт болон богино хугацааны аян, хөдөлгөөнийг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах” нэгдүгээр зорилтын хүрээнд:

4.1.1. Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулах

4.1.2. Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх

4.1.3. “Нэг иргэн-Нэг мод”, “Нэг машин-Нэг мод” гэх мэт аянуудыг өрнүүлэх

4.1.4 Шинээр баригдсан барилга байгууламжийг ногоон байгууламжийн хамт хүлээн авч байх

4.1.5 Төв суурин газрын үерийн хамгаалалтын далан, сувгийг засаж сайжруулах

4.1.6 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, мод тарих өдөрт өргөнөөр оролцуулах

4.2. “Мэргэжлийн боловсон хүчээр хангаж, техник тоног төхөөрөмж шинэчилхэд дэмжлэг үзүүлэх” хоёрдугаар зорилтын хүрээнд:

4.2.1 Ногоон байгууламж, ойжуулалтын чиглэлээр богино хугацааны сургалтанд хамруулах

4.2.2 Аймгийн МСҮТ-д ойжуулалт, нөхөн сэргээлтийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх

4.2.3 Ногоон байгууламж хариуцсан тасаг байгуулах

4.2.4 Усалгааны машин, техник хэрэгслээр хангах

4.2.5 Хөрсний шинжилгээ хийлгэх

4.3. “Сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, иргэдийг түшиглэн сумдад мод үржүүлгийн газар байгуулах мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөх” гуравдугаар зорилтын хүрээнд:

4.3.1 Сумдад байгуулагдсан мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг тогтворжуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр хангах

4.3.2 Мод үржүүлгийн газруудыг өргөтгөх, шинээр мод үржүүлгийн газар байгуулахад дэмжлэг үзүүлэх.

4.3.3 Мод үржүүлэх шинэ дэвшилтэт технологийг судлан нэвтрүүлэх

4.3.4 Модны үр, боргоцой, тарьц, суулгац бойжуулах ажилд нутгийн иргэд олон нийтийг өргөнөөр оролцуулж, ойг нөхөн сэргээх

4.4 “Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн үүсгэл санаачилга, оролцоог нэмэгдүүлж олон нийтэд сурталчлах” дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.4.1 Алтайгаа ногооруулья цуврал нэвтрүүлэг бэлтгэн мод тарьсан сайн туршлагыг олон нийтэд сурталчлах

4.4.2 Газрын доройтол, цөлжилтийг сааруулахад чиглэсэн ногоон зурвас байгуулах ажлыг эрчимжүүлэх

4.4.3 Газрын доройтол, цөлжилтийг сааруулахад чиглэсэн ногоон зурвас байгуулах ажлыг эрчимжүүлэх.

4.4.4 Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг нэрэмжит “Ногоон төгөл” байгуулах, мод бут сөөг тарихад дэмжлэг үзүүлэх.

4.4.5 Төрөл бүрийн гоёлын мод, жимс жимсгэний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа, сургалт сурталчилгаа зохион байгуулах.

4.5 “Төв суурин газрын усан хангамж, ногоон байгууламжийн усалгааны асуудлыг шийдвэрлэх” тавдугаар зорилтын хүрээнд

4.5.1 Булгийн эхийг хашиж хамгаалах ажлын үргэлжлүүлэн хийх

4.5.2 Сумдад ногоон байгууламжийн усалгаанд зориулж худаг гаргах ёмкос байрлуулах

4.5.3 Хөв цөөрөм байгуулах

4.5.4 Дуслын услалтын систем суурилуулах

4.5.5 Шинээр мод нэмж тарьж байгаа газруудад дуслын услалтын систем суурилуулах

4.6 “Заг болон шинэсэн ойг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ авч, нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалах” зургаадугаар зорилтын хүрээнд

4.6.1 Шинэсэн ой цэвэрлэх ажлыг нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоотойгоор хамтран зохион байгуулах

4.6.2 Ой хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр зохион байгуулах

4.6.3 Ой хээрийн түймрээс хамгаалах, унтраах багаж хэрэгслээр хангах

4.6.4 Ойн хөнөөлт шавьж, өвчин хортны судалгаа явуулж урьдчилан сэргийлэх, тэмцэх

4.6.5 Заган ойг үрээр тарих, нөхөн сэргээх хамгаалах үйл ажиллагаа явуулж буй иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын ажилд дэмжлэг үзүүлэх

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Удирдлага зохион байгуулалт

5.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих эрх, үүргийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг хэрэгжүүлэх бөгөөд сумын түвшинд сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг хариуцна.

5.1.2. Ажлын хэсгийг Засаг даргын орлогч ахлаж, ажлын хэсгийн гүйцэтгэх бүрэлдэхүүний шуурхай удирдлагыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст төвлөрүүлэн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Сум дундын ойн анги, Хот тохижилт үйлчилгээний газар болон төрийн бус байгууллага иргэний төлөөлөл тус тус орсон байна.

5.1.3. Ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэл

- ❖ Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах
- ❖ Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх хөтөлбөрт өөрчлөлт оруулах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх
- ❖ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд оролцох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог зохицуулах, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах нөхцлийг бүрдүүлэх
- ❖ Сумдын салбар ажлын хэсгийг арга зүйн удирдлагаар хангах
- ❖ Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах

5.1.4 Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн иргэдийн үүсгэл санаачлага, идэвх оролцоог дэмжиж өргөнөөр татан оролцуулах.

5.2 Санхүүжилт

- 5.2.1 Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
- 5.2.2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
- 5.2.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгө
- 5.2.4. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж
- 5.2.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- 5.2.6. Бусад эх үүсвэр

Зургаа. Шалгуур үзүүлэлт

- 6.1. Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2 дахин өссөн байна.
- 6.2. Аймгийн хэмжээнд шинээр баригдаж буй байшин барилга бүрийн талбайн 20-с доошгүй хувьд ногоон байгууламжтай болсон байна.
- 6.3. “Нэг иргэн-Нэг мод”, “Нэг машин-Нэг мод” зэрэг аяныг тогтмол зохион байгуулж жил бүр 20.000-аас доошгүй мод тарьсан байна.
- 6.4. Тариалан эрхлэгч аж ахуйн нэгж бүр ногоон зурвас байгуулж, нийт тариалангийн талбайн 20 хувьд зурвас байгуулж салхи, элсний нүүлтээс хамгаална.
- 6.5. Шинээр байгуулагдсан, өргөжүүлсэн мод үржүүлгийн газруудын модны тарьц, суулгацын төрлийг нэмэгдүүлж чанар сайтай, шаардлага хангасан тарьц, суулгацыг зах зээлд нийлүүлсэн байна.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

- 7.1. Төв суурин газрын тохижилт, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, ойжуулалт хийх, ногоон зурвас байгуулах, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас эрчимтэй явагдаж байгаа цөлжилтийг сааруулах зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 7.2. Байгаль орчноо хайрлан хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөц баялаг, хог хаягдал бага гарах, хоёрдогч түүхий эд ашиглах, байгаль орчинд ээлтэй үйлчилгээ, экологийн тэмдэгтэй, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэх зэрэг ногоон хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж “Ногоон Алтай” бүс нутаг болно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
30-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 11 хавсралт

НОГООН АЛТАЙ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2017-2020 он/

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Санхүүжилт	Зохион байгуулагч	
						Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
Нэг. "Төв суурин газрын тохижилтыг сайжруулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор урт болон богино хугацааны аян, хөдөлгөөнийг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах" зорилтын хүрээнд:							
1.1	Тохижилт бүтээн байгуулалтын ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулах	2018- 2020	Талбайн хэмжээ	3 га-аас доошгүй	АОНХС 5 сая СОНХС 51 сая	Сумдын ЗДТГ	Аймгийн ЗДТГ БОАЖГ Есөнбулаг сумын ЗДТГ, СДОА, ХХҮГ, Тохижилт Ү.Г
1.2	Төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	2017- 2020	Нэмэгдсэн хэмжээ	2 дахин нэмэгдсэн байна.	АОНХС 30 сая СОНХС 190 сая	АЗДТГ, Сумдын ЗДТГ	БОАЖГ, СДОА, ХХҮГ Тохижилт Ү.Г
1.3	"Нэг иргэн-Нэг мод", "Нэг машин-Нэг мод" аян өрнүүлнэ	2019-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	20000-с доошгүй мод таригдсан байна.	АОНХС 30 сая СОНХС 190 сая	Сумдын ЗДТГ, БОАЖГ	СДОА, ХХҮГ Тохижилт Ү.Г
1.4	Шинээр баригдсан барилга байгууламжийг ногоон байгууламжийн хамт хүлээн авч байх	2018 -2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шинээр баригдаж байгаа барилга бүр гадна талдаа ногоон байгууламж бий болгосон байна.	-	Сумдын ЗДТГ ГХБХБГ	БОАЖГ, СДОА
1.5	Төв суурин газрын үерийн хамгаалалтын далан, сувгийг засаж сайжруулах	2018-2019	Сумын тоо	2-с доошгүй сумд	АОНХС 80 сая СОНХС 90 сая	Сумдын ЗДТГ	АЗДТГ, ОБГ, ГХБХБГ,
1.6	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж мод тарих өдөрт өргөнөөр оролцуулах	2017-2020	Жилд оролцсон хүний тоо	5000-аас доошгүй	-	Сумдын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ, Төсөл хөтөлбөр
Хоёр. "Мэргэжлийн боловсон хүчээр хангаж, техник тоног тохооромж шинэчилхэд дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд:							
2.1	Агрономич, ойжуулалтын чиглэлээр богино хугацааны сургалтанд хамруулах	2018-2019	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жилд 2-оос доошгүй хүн сургалтанд хамрагдсан байна.	АОНХС 1 сая СОНХС 3 сая	СДОА	АЗДТГ, МСҮТ
2.2	Аймгийн МСҮТ-д ойжуулалт нөхөн сэргээлтийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх	2018	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Мэргэжилтэн бэлтгэдэг болсон байна	-	МСҮТ	АЗДТГ, СДОА
2.3	Ногоон байгууламж хариуцсан тасаг байгуулах	2018	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Ногоон байгууламж хариуцсан тасагтай болсон байна	ХХАХЗ 12,5 сая	Есөнбулаг сумын ЗДТГ	АЗДТГ, БОАЖГ, СДОА

8/11/2017

2.4	Усалгааны машин, техник хэрэгслээр хангах	2018	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Усалгааны машинтай болсон байна	ХХАХЗ 50 сая	Есөнбулаг	АЗДТГ, Төхижилт Ү.Г
2.5	Хөрсний шинжилгээ хийлгэх	2018	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн төвийн мод тарих боломжтой газруудад хөрсний шинжилгээ хийгдсэн байна	СОНХС 1.5 сая	БОАЖГ	Улаанбаатар хот дахь нутгын зөвлөл
Гурав: "Сум дундын ойн анги, ойн нөхөрлөл, иргэдийг түшиглэн сумдад мод үржүүлгийн газар байгуулах мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлж өргөтгөх" зорилтын хүрээнд:							
3.1	Сумдад байгуулагдсан мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг тогтворжуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгслээр хангах	2019 2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шаардлагатай багаж хэрэгслээр хангагдсан байна	АОНХС 10 сая	АЗДТГ, СДОА	ХХААХҮГ, БОАЖГ
3.2	Мод үржүүлгийн газруудыг өргөтгөх, шинээр мод үржүүлгийн газар байгуулахад дэмжлэг үзүүлэх	2019 2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Мод үржүүлгийн газар 3 га талбайгаар нэмэгдсэн байна	СОНХС 30 сая	АЗДТГ, Сумдын ЗДТГ	БОАЖГ, ХХААХҮГ, СДОА
3.3	Мод үржүүлэх шинэ дэвшилтэт технологийг судлан нэвтрүүлэх.	2019 2020	3 сумд	Бусад аймгуудаас туршлага судалж нэвтрүүлсэн байна	-	СДОА	БОАЖГ
3.4	Модны үр, боргоцой, тарьц, суулгац бойжуулах ажилд нутгийн иргэд олон нийтийг өргөнөөр оролцуулж, ойг нөхөн сэргээх	2019 2020	2-оос доошгүй сум	Мод үржүүлгийн газруудад Шинэсний үр тарималжуулж эхэлсэн байна	АОНХС 3 сая	СДОА,	Сумдын ЗДТГ, БОАЖГ
Дөрөв. Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн үүсгэл санаачилга, оролцоог нэмэгдүүлж олон нийтэд сурталчлах							
4.1	"Нэг иргэн - Нэг мод", "Нэг машин-Нэг мод" зэрэг аян зохион байгуулах	2019 2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	50000-с доошгүй мод таригдсан байна.	АОНХС 80 сая СОНХС 180 сая	Сумдын ЗДТГ, БОАЖГ	СДОА, ХХҮГ Төхижилт Ү.Г
4.2	Алтайгаа ногооруулья цуврал нэвтрүүлэг бэлтгэн мод тарьсан сайн туршлагыг олон нийтэд сурталчлах	2018 2019 2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сум бүрийн сайн туршлагыг олон нийтэд хүргэсэн байна	АОНХС 5 сая	Олон нийтийн радио МНТ БОАЖГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ, СДОА
4.3	Газрын доройтол, цөлжилтийг сааруулахад чиглэсэн ногоон зурвас байгуулах ажлыг эрчимжүүлэх	2017-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жилд 3-аас доошгүй га талбайд ойн зурвас байгуулагдсан байна	АОНХС 6 сая СОНХС 36 сая	Аймаг, сумдын ЗДТГ,	БОАЖГ, БОИЗөвлөл, СДОА
4.4	Байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг нэрэмжит "Ногоон төгөл" байгуулах, мод бут сөөг тарихад дэмжлэг үзүүлэх	2018-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Нэрэмжит төгөлтэй болсон байна	АОНХС 3 сая СОНХС 18 сая	АЗДТГ	БОАЖГ, ХААЖДҮГ, ГХБХБГ, Сумдын Засаг дарга нар,

179

4.5	Төрөл бүрийн гоёлын мод, жимс жимсгэний тарьц, суулгацын үзэсгэлэн худалдаа, сургалт сурталчилгаа зохион байгуулах	2018-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулах	-	СДОА	МХГ, БОАЖГ, иргэн, ААН
Тав: Төв суурин газрын усан хангамж, ногоон байгууламжийн усалгааны асуудлыг шийдвэрлэх:							
5.1	Булгийн эхийг хашиж хамгаалах ажлын үргэлжлүүлэн хийх	2017-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жилд 3-с доошгүй булаг	ХХАХЗ 6 сая	БОАЖГ	Сумын ЗДТГ
5.2	Сумдад ногоон байгууламжийн усалгаанд зориулж худаг гаргах ёмкос байрлуулах	2018-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сум бүрт хийгдэх шаардлагатай байна	АОНХС 25 сая СОНХС 360 сая	АЗДТГ, Сумын ЗДТГ	ХХААГ
5.3	Хөв цөөрөм байгуулах	2018-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2-аас доошгүй	Улсын төсөв, СОНХС 150 сая	АЗДТГ, БОАЖГ	Сумын ЗДТГ, мэргэжлийн байгууллага
5.4	Дуслын услалтын систем суурилуулах	2018	5.3 га	Солонго хороололд хийгдсэн байна	-	Нутгийн зөвлөл	Тохижилт Ү.Г
5.5	Шинээр мод нэмж тарьж байгаа газруудад дуслын услалтын систем суурилуулах	2018-2019	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2-с доошгүй газар	АОНХС 15 сая	АЗДТГ	БОАЖГ, Тохижилт Ү.
Зургаа: Заг болон шинэсэн ойг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ авч, нутгийн иргэдийн оролцоотойгоор хамгаалах зорилтын хүрээнд:							
6.1	Шинэсэн ой цэвэрлэх ажлыг нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоотойгоор хамтран зохион байгуулах	2017-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жилд 50-с доошгүй га талбайд хийгдсэн байна	-	СДОА	БОАЖГ, СЗДТГ
6.2	Ой хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг жил бүр зохион байгуулах	2018	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Жил бүрийн хуурайшилт ихтэй үед хамтарч ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна	-	СДОА	БОАЖГ, ЦГ, ОБГ
6.3	Ой хээрийн түймрээс хамгаалах, унтраах багаж хэрэгсэлээр хангах	2019 -2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Ой хээрийн түймрээс хамгаалах, ойн сан бүхий 5 сум унтраах багаж хэрэгсэлээр хангагдсан байна	АОНХС 3,2 сая СОНХС 37,8 сая	ОБГ, АЗДТГ	СДОА, БОАЖГ
6.4	Ойн хөнөөлт шавьж, өвчин хортны судалгаа явуулж урьдчилан сэргийлэх, тэмцэх	2017-2020	Ойн сан бүхий сумдад	Жил бүр хортны судалгааны ажил хийгдсэн байна	Улсын төсөв	СДОА	БОНХАЖЯ, Мэргэжлийн байгууллага БОАЖГ
6.5	Заган ойг үрээр тарих, нөхөн сэргээх хамгаалах үйл ажиллагаа явуулж буй иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын ажилд дэмжлэг үзүүлэх	2019-2020	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Заган ойг нөхөн сэргээх арга хэмжээ авч туршилтын журмаар ойжуулалт хийгдсэн байна	АОНХС 3 сая	СДОА	АЗДТГ, БОАЖГ, сумын ЗДТГ,

180
098